



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/761

Ховд

Газар хөдлөлийн хөрсний хурдатгал хэмжигч
багаж суурилуулах ажлыг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Одон орон, геофизикийн хүрээлэнгийн хийж гүйцэтгэсэн Газар хөдлөлийн хөрсний хурдатгал хэмжигч багаж суурилуулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд: Д.Нямтулга	- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч
Б.Түмэндэмбэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Туулайтулга	- Жаргалант сумын Засаг даргын орлогч
М.Баярт	- Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Ц.Цолмонбаатар	- Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
Ц.Даваасамбуу	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
С.Батдорж	- Аймгийн Архивын тасгийн дарга

- | | |
|------------------------------------|--|
| Ч.Одонбаатар | - Одон орон, геофизикийн хүрээлэнгийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга |
| С.Загдсүрэн | - Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Ховд салбарын эрхлэгч |
| Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж | - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн |

2. Одон орон, геофизикийн хүрээлэнгийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН